



АРХАНГАЙ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

Хөдөө аж ахуйн салбар 2019 он



АГУУЛГА

Оршил

I. Эдийн засагт хөдөө аж ахуйн салбарын эзлэх байр суурь

II. Мал аж ахуй

II.1. Мал аж ахуйн салбарын үйлдвэрлэлт

II.2. Малын 2019 оны тооллогын дүн

II.2.1. Малтай болон малчин өрх, малчид,
тэдгээрийн соёл ахуйн үзүүлэлтүүд

II.2.2. Мал, тэжээвэр амьтдын тоо, сүргийн бүтэц

Малтай өрхийн бүлэглэлт

Малчин өрхийн бүлэглэлт

Хээлтэгч малын тоо

Төл бойжилт

Малын зүй бус хорогдол

Хээл хаялт, сувайралт

Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо

Малын хэрэглээний зарлага

Сүргийн бүтэц

Сарлагын тоо

II.2.3. Үүлдрийн болон шилдэг омгийн мал

II.2.4. Малын бэлчээр, тэжээлийн хүрэлцээ, хангамж

II.2.5. Тэжээвэр амьтад

II.2.6. Худаг, малын хашааны тоо, багтаамж

II.2.7. ХАА-д ажиллаж байгаа мэргэжилтэй боловсон хүчин

II.2.8. ХАА-д ашиглагдаж байгаа машин техникийн тоо

II.2.9. Малжуулах арга хэмжээний талаарх мэдээлэл

II.2.10. Шинээр гаргасан, засварласан худаг

II.3. Мал эмнэлгийн үйлчилгээ

II.4. Багуудын малын тоо толгой

II.4. Улсын малын тоо толгой

III. Газар тариалан

III.1. Тариалсан талбай

III.2. Газар тариалангийн үйлдвэрлэл, хураасан ургац

III.3. Га-гийн ургац

III.4. Хөдөө аж ахуйн эдэлбэр газар

Дүгнэлт

Хавсралтууд

НЭР ТОМЬЁОНЫ ТОВЧ ТАЙЛБАР, ТОДОРХОЙЛОЛТ

Малтай өрх. Малыг ахуй амьдралдаа туслах чанарын үүрэгтэй өсгөн үржүүлдэг өрх

Малчин өрх. Жилийн 4 улирлын туршид малаа маллаж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр нь болж байгаа өрх

Малчид. Жилийн 4 улирлын туршид мал аж ахуй эрхэлж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа 16 ба түүнээс дээш насны хүмүүсийг хэлнэ.

Бодод шилжүүлэх коэффициент:

1 адуу, үхэр - 1 бод
1 тэмээ - 1.5 бод
6 хонь - 1 бод
8 ямаа - 1 бод

Бодод шилжүүлэх коэффициентийг таван төрлийн малыг нэг төрлийн малд шилжүүлэн малын өсөлт, бууралтыг гаргах, үр ашгийг тооцоход ашиглана.

Бог малд буюу хонин толгойд шилжүүлэх коэффициент:

1 тэмээ - 5 хонь
1 адуу - 7 хонь
1 үхэр - 6 хонь
1 хонь - 1 хонь
1 ямаа - 0.9 хонь

Бодод шилжүүлэх коэффициентийг малын тэжээлийн хүрэлцээ, хангамж, бэлчээрийн даацыг тодорхойлон гаргахад ашиглана.

Нас гүйцсэн мал. Малын төрөл бүр дээр дараах насны малыг хамруулна.

Тэмээ - 4 настай, 5 ба түүнээс дээш настай

Адуу - 3 настай, 4 ба түүнээс дээш настай

Үхэр - 2 настай, 3 ба түүнээс дээш настай

Бог мал - тухайн жилийн төл малаас бусад насны мал

Өсвөр насны мал

Тэмээ-Өмнөх оны төл, 2, 3 настай

Адуу- Өмнөх оны төл, 2 настай

Үхэр- Өмнөх оны төл

Төл мал. Тухайн жилийн төлийг хэлнэ.

Бэлэн хээлтэгч. Малын төрөл бүр дээр нас гүйцсэн эм малыг хамруулна.

Малын тоо, толгойн өсөлт. Оны эцсийн малаас оны эхний малыг хасч, малын тооны өөрчлөлтийг тоогоор илэрхийлнэ. Оны эцсийн малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлж, өсөлт, бууралтыг хувиар илэрхийлнэ.

Малын өсөлтийн орлого тал нь төл бойжилт, зарлага тал нь хэрэглээний зарлага, том малын зүй бус хорогдол байна.

Төллөлтийн хувь. Төллөсөн хээлтэгчийн тоог оны эхний хээлтэгчийн тоонд харьцуулан, 100 –гаар үржүүлэн тооцно.

Бойжилтын хувь. Бойжсон төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулан 100–гаар үржүүлэн тооцно.

100 эхээс бойжуулсан төл. Бойжуулсан төлийн тоог оны эхний хээлтэгч малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлэн тооцно.

Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо. Хээлтэгч малын тоог хээлтүүлэгч малын тоонд харьцуулж, тооцно.

I хээлтүүлэгчид ногдох хээлтэгчийн тооны норм нь:

Буур -	20-25
Азарга -	12-15
Бух -	35-45
Хуц, ухна -	25-30

Том малын зүй бус хорогдолд өвчний (халдвартай, халдваргүй) хорогдол, гэнэтийн аюулын (цас зуд, үер ус, гал түймэр, аянга цахилгаан зэрэг) хорогдол, бусад шалтгааны (малын хариулга, арчилгаа маллагаатай холбогдон гарсан) хорогдлыг хамруулна.

Том малын зүй бус хорогдлын оны эхний малд эзлэх хувь. Зүй бусаар хорогдсон том малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлэн тооцно.

Малын хэрэглээний зарлага.

Оны эхний малын тоон дээр бойжуулсан төлийг нэмж, том малын зүй бус хорогдол, оны эцсийн малын тоог хасч, тооцно.

Малын хашааны хангамж. Хашааны хангамжийг гаргахдаа хашааны багтаамжийг малын тоонд харьцуулж тооцно. Бод малын хашааны хангамжийг гаргахдаа бодын хашааны багтаамжийг үхрийн тоонд, харин бог малынхыг богийн хашааны багтаамжийг бог малын /хонь, ямааны/ тоонд харьцуулж тооцно.

Тэжээл хангамж. Тэжээлийн хангамжийг гаргахдаа тэжээлийн нэгжид шилжүүлсэн тэжээлийн хэмжээг хонин толгойд шилжүүлсэн малын тоонд харьцуулан тооцно. Малын тэжээлийн хангамж, бэлчээрийн даацыг гаргахдаа малыг хонин толгойд шилжүүлснээр тооцно.

Тэжээлийн нэгжид шилжүүлэх коэффициент. Бэлтгэсэн тэжээл нь илчлэг, чанарын байдлаараа харилцан адилгүй байдаг учраас нэг тэжээлийн нэгжид шилжүүлж тэжээлийн хангамжийг гаргана. Үүний тулд:

Хадлан өвс	-	0.45
Таримал тэжээл	-	0.35
Даршны ургамал	-	0.25
Гар тэжээл, хужир шүү	-	1.00
Төмс ногооны хаягдал	-	0.22
Үр тарианы хаягдал	-	0.90
Лай	-	0.40
Сүрэл	-	0.25

гэсэн итгэлцүүрүүдийг ашиглан тэжээлийн нэгжид шилжүүлнэ.

Малын тэжээлийн ангилал. Малын тэжээлийг ургамлын гаралтай, амьтны гаралтай, эрдэс тэжээлийн гаралтай гэж ангилна.

- Ургамлын гаралтай тэжээлд өвс, сүрэл, үр тариа, буурцгийн төрлийн ургамал багтах бөгөөд бүдүүн, хүчит, шүүст тэжээл гэж ангилна.
 1. Бүдүүн тэжээл- өвс, сүрэл, нэг наст ба олон наст өвс орно.
 2. Хүчит тэжээл- үр тариа, үр тарианы хаягдал, вандуй, буурцаг орно.
 3. Шүүст тэжээл - Бүх төрлийн дарш, төмс ногооны хаягдал орно.
- Амьтны гаралтай тэжээлд яс, цусны гурил зэрэг орно.
- Эрдэс тэжээлд давс, хужир шүү орно.

Тариалангийн талбай . Хөдөө аж ахуйн таримал ургамлыг тариалсан талбайг хэлнэ. Тариалангийн талбайг тариалсан талбай, хураасан талбай, өнжсөн талбай, уринш боловсруулсан талбай гэж ангилна.

Тариалсан талбай. Тухайн жилд үр суулгасан газрын нийт талбайн хэмжээг хэлнэ.

Хураасан талбай. Тухайн жилд ургацыг хурааж авсан газрын нийт талбайн хэмжээг хэлнэ.

Га-гийн ургац. Талбайн нэг нэгжээс /1 га-гаас/ авах газар тариалангийн бүтээгдэхүүний /ургацын/ хэмжээ бөгөөд га-гийн ургацыг тодорхойлохдоо тухайн төрлийн ургамлын хурааж авсан бүх ургацыг тариалсан талбайн хэмжээнд нь харьцуулж тодорхойлно.

Нийт ургац. Тухайн жилд газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлж үйлдвэрлэсэн нийт бүтээгдэхүүний хэмжээ, өөрөөр хэлбэл, тариалсан бүх талбайгаас хураан авсан үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, малын тэжээл, техник, тосны ургамал зэрэг ургамал тус бүрийн төрлөөр нэмж гаргасан нийт ургацын хэмжээ болно.

Төвчилсон тэмдэглэгээ:

Сүмдын нэр:

Их - Ихтамир
 Чу - Чулуут
 Хн - Хангай
 Та - Тариат
 Өу – Өндөрүлаан
 Эм – Эрдэнэмандал
 Жа - Жаргалант
 Цц - Цэцэрлэг
 Хр - Хайрхан
 Бц - Батцэнгэл
 Өл - Өлзийт
 Өг - Өгийннуур
 Хш - Хашаат
 Хт - Хотонт
 Цн - Цэнхэр
 Тө - Төвшрүүлэх
 Бу - Булган
 Эбу- Эрдэнэбулган
 Цр - Цахир

ОРШИЛ

Хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагаа нь бусад хүчин зүйлээс илүүтэйгээр байгаль, цаг агаараас хамааралтай бөгөөд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь үндсэндээ хүн амын хүнсний хэрэглээ, боловсруулах үйлдвэрлэлийн болон үйлчилгээний салбарын түүхий эдийн хэрэглээг хангахад чиглэгддэг.

Дэлхийн олон улс орнуудын нэгэн адил манай улсын эдийн засгийн хөгжилд хөдөө аж ахуйн салбар нь ихээхэн чухал байр эзэлдэг салбарын нэг юм.

Энэ удаагийн танилцуулгад мал аж ахуйн, газар тариалангийн салбарын 2019 оны төлөв байдлыг нэгтгэн тусгалаа.

“Монгол Улсын Үндсэн хууль”-нд “Мал сүрэг”-ийг үндэсний баялаг мөн гэж хуульчлан зааж, мал тооллогыг улсын хэмжээнд жил бүр зохион байгуулж, үр дүнг нь макро түвшинд хийгддэг тооцоо, судалгаанд ашиглаж, салбарын талаар удирдлагын шийдвэр гаргах мэдээллийн гол эх үүсвэр болгон ашиглаж байна.

“Статистикийн тухай” Монгол Улсын хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 224 дүгээр тогтоолын дагуу Статистикийн хэлтсээс мал, тэжээвэр амьтад, тэжээлийн тооллогыг 2019 оны 12 сарын 7-ноос 17-ны өдрүүдэд улсын хэмжээнд зохион байгуулж, явууллаа .

Малын 2019 оны тооллогыг уламжлалт маягт, зааврын дагуу явуулж, өрх нэг бүрээр онлайнд шивж үр дүнг нэгтгэн гаргалаа.

Энэхүү танилцуулгад малын 2019 оны тооллогын дүнг нэгтгэн дүгнэснээс гадна мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүн, мал эмнэлгийн арга хэмжээ, шинээр гаргасан, сэргээн засварласан худаг, уст цэгийн талаархи мэдээллийг тусган орууллаа.

Түүнчлэн уг танилцуулгад газар тариалангийн салбарын үндсэн үзүүлэлтүүд болох тариалсан талбай, хураасан ургац, га-гийн ургацын талаарх мэдээллийг жилийн дүнгээр нэгтгэн тусгасан болно.

Танилцуулгыг сумдаар болон аймгийн дүнгээр зэрэгцүүлэлт хийж харуулав.

Манай аймгийн хөдөө аж ахуйн салбарын өнөөгийн байдалд дүгнэлт хийж,цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг боловсруулах, төлөвлөхөд энэхүү танилцуулга, судалгааны материал суурь мэдээлэл нь болно гэдэгт итгэж байна.


I. Эдийн засагт мал аж ахуйн салбарын эзлэх байр суурь

Хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагаа нь бусад хүчин зүйлээс илүүтэйгээр байгаль, цаг агаараас ихээхэн хамааралтай бөгөөд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн нь үндсэндээ хүн амын хүнсний хэрэглээ, боловсруулах үйлдвэрлэлийн салбарын үйлдвэрлэлийг явуулахад гол түүхий эд болдог онцлогтой.

2019 оны урьдчилсан байдлаар манай аймгийн ДНБ (Дотоодын нийт бүтээгдэхүүн)-ий урьдчилсан байдлаар 59.5 орчим хувийг хөдөө аж ахуйн салбар бүрдүүлж, ажиллах хүчний 54.1 хувь нь энэ салбарт ажиллаж байна.

Зураг 1

ДНБ-д ХАА-н салбарын нэмэгдэл өртгийн эзлэх хувь



Хөдөө аж ахуйн салбар, үүний дотор мал аж ахуйн салбарын үйлдвэрлэл нь боловсруулах аж үйлдвэрийн салбарын хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл, нэхмэл эдлэл үйлдвэрлэлийн салбарын түүхий эдийг нийлүүлж, боловсруулах салбар болон үйлчилгээний салбарын үйлдвэрлэлийн өсөлтийг хангах, газар тариалангийн салбар нь хүн амыг аюулгүй баталгаат хүнсээр хангах үндсэн нөхцөл нь болсоор байна.

II. МАЛ АЖ АХУЙ

II.1 Мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт

Мал аж ахуйн салбарт 2019 онд 89.8 мянган литр сүү, 2.9 мянган тонн хонины ноос, 0.5 мянган тонноолуур, 4.3 кг тэмээний ноос, 255.2 мянган ширхэг арьс, шир үйлдвэрлэв. Өмнөх оныхтой харьцуулахад сүүний үйлдвэрлэл 20.1 мянган литрээр, бодын хялгас 7.3 тонн, бодын хөөвөр 13.2 тонноор өсч, харин арьс, шир 103.3 мянган ширхгээр, ноолуур 61.5 тонн, хонины ноос 807.9 мянган тонноор буурсан байна.

Мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, биет хэмжээ

Хүснэгт 1

	2015	2016	2017	2018	2019	өөрчлөлт	
						хувь	зөрүү
Сүү,мян,литр	91012.1	92534.8	102133	89824.6	109942.9	122.4	20118.3
Ингэний	41	46.1	49.2	46.8	56.1	119.9	9.3
Гүүний	19946.5	20249.6	23754.8	19449.5	25974.4	133.5	6524.9
Үнээний	50020.0	50161.7	53597.2	48879.6	56884.2	116.4	8004.6
Хонины	11660.7	12185.9	14034.8	12884	15534.4	120.6	2650.4
Ямааны	9343.9	9891.5	10697.0	8564.7	11493.8	134.2	2929.1
Ноос,ноолуур,тн	2593.8	2752.7	2937	4332.4	3606.9	83.3	-725.5
Тэмээний ноос	3.4	3.9	5.9	3.9	4.3	110.3	0.4
Хонины ноос	2078.6	2429.0	2588.4	3734.4	2926.5	78.4	-807.9
Ямааны ноолуур	373.6	199.0	212.8	440.8	502.3	114.0	61.5
Бодын хөөвөр	89.6	72.4	78.0	96.9	110.1	113.6	13.2
Бодын хялгас	48.6	48.4	51.9	56.4	63.7	112.9	7.3
Арьс шир,мян.шир	260.70	266.61	286.62	358.6	255.22	71.2	-103.3
Тэмээний	0.002	0.006	0.02	0.05	0.02	40.0	0.0
Адууны	14.0	13.4	15.4	26.7	12.8	47.9	-13.9
Үхрийн	24.4	40.0	28.4	50.5	23.7	46.9	-26.8
Хонины	130.3	125.1	143.1	170.7	136.6	80.0	-34.1
Ямааны	92.0	88.1	99.7	110.6	82.1	74.2	-28.5

II.2.1 Мал бүхий өрх, малчдын тоо, тэдний соёл ахуйн үзүүлэлтүүд

Мал бүхий өрх малчдын тоо. Мал тооллогын 2019 оны дүнгээр аймгийн хэмжээнд 19.1 мянган малтай өрх тооллогдсон байна. Үүний 79.6 хувь буюу 15.2 мянган өрх нь жилийн дөрвөн улирлын турш малаа малладаг, малын ашиг шим нь тэдний амжиргааны эх үүсвэр болж байгаа малчин өрх, 20.4 хувь буюу 3.9 мянган өрх нь малыг амьдрал ахуйдаа туслах чанартайгаар өсгөн үржүүлж буй мал бүхий өрх байна.

2019 онд мал аж ахуйн үйлдвэрлэлд 25.7 мянган малчид ажиллаж байна. Малчдын 42.8 хувь буюу 11.0 мянга нь эмэгтэй малчид байна.

Насны бүлгээр авч үзвэл 32.3 хувь нь 16-34 насны, 55.6 хувь нь 35-аас тэтгэвэрт гарах хүртэлх насныхан, 12.1 хувь нь тэтгэврийн насны хүмүүс байна.

Хүнэгт 2

Өрх, малчдын тоо, насны бүрэлдхүүн

	2015	2016	2017	2018	2019	2019/2018	
						хувь	зөрүү
Малтай өрх, (мян)	17.4	17.8	18.4	18.8	19.1	101.6	0.3
Малчин өрх, (мян)	14.1	14.4	15.2	15.0	15.2	101.3	0.2
Малчдын тоо, (мян)	26.9	27.5	27	25.7	25.7	100.0	0.0
Үүнээс: 16-34 насны	9.8	9.9	9.4	8.7	8.3	95.4	-0.4
35-аас тэтгэвэрт гарах насны	14.5	15	14.2	13.9	14.3	102.9	0.4
Тэтгэврийн	2.5	2.3	3.4	3.1	3.1	100.0	0.0
Нийт малчдаас эмэгтэй	12.7	12.8	12.2	11.3	11.0	97.3	-0.3
Насны бүрэлдхүүн %	100	100	100	100	100	100.0	0.0
Үүнээс: 16-34 насны	36.4	36.1	34.8	33.9	32.3	95.3	-1.6
35-аас тэтгэвэрт гарах насны	53.9	54.5	52.6	54.1	55.6	102.9	1.5
Тэтгэврийн	9.7	9.4	12.3	12	12.1	100.5	0.1
Нэг малчин өрхөд ногдох малын тоо	316	347	348	366	367	100.3	1.0

2019 оны малчин өрхийн тоо 2018 онтой харьцуулахад 0.2 мянгаар өсч харин малчдын тоо өмнөх онтой ижил түвшинд байна.

Малчин өрхийн тоо Эрдэнэмандал /43/, Хангай /14/, Жаргалант /7/, Хашаат /5/, Эрдэнэбулган /108/, Ихтамир /35/, Чулуут/5/, Тариат/10/, Өлзийт/26/, Өгийнуур 21 Өндөр-Улаан /34/, Булган /25/, Цэнхэр/4/ сумдад өсч бусад сумд 1-37-оор бурсан байна.


Малчдын тоог сумдаар авч үзвэл Батцэнгэл /30/, Өгийнуур /15/, Эрдэнэбулган /12/, Тариат /7/ сумдад өнгөрсөн оныхоос өсч, бусад сумдад 16-413-аар буурсан байна.

2019 онд 1 малчин өрхөд 321 толгой мал ногдож, өнгөрсөн оныхоос 45 толгойгоор буурсан байна. Энэ малын тоо өссөн ч малдын тоо өссөн нь нэг малчинд ногдох малын

тоо буурхад нөлөөсөн байна. Нэг малчин өрхөд ногдох малын тоо Тариат, Батцэнгэл, Өгийнуур, Эрдэнэбулган, Цахир сумдад 1-103 толгой малаар буурч, бусад сумдад 1-267 толгой малаар өсчээ.
(Хавсралт 9,10).

Зураг 2

Малчдын тоо, мян, хүн



Малчдын нийгэм ахуйн зарим үзүүлэлт. 2019 оны тооллогоор нийт малчин өрхийн 84.2 хувь нь цахилгааны эх үүсгүүртэй, 72.4 хувь нь телевизортой, 46.5 хувь нь авто машинтай, 54.2 хувь нь мотоциклтэй, 1.2 хувь нь трактортой байна.

Сүүлийн 12 жилд хөдөө орон нутагт нар, салхины цахилгааны эх үүсгүүрийн хэрэглээ нэмэгдэж, 2018 оныхоос цахилгаантай өрхийн тоо 0.6 мянгаар буюу 5.1 хувиар, телевизортой өрхийн тоо 0.6 мянгаар буюу 5.7 хувиар, авто машинтай өрхийн тоо 2.6 мянгаар буюу 59.1 хувиар, мотоциклтэй өрхийн тоо 0.7 мянгаар буюу 9.4 хувиар нэмэгдэж, харин трактортой өрхийн тоо буурсан байна.


Малчдын нийгэм соёлын үзүүлэлт

Хүснэгт 3

	Малчин өрхийн тоо				2019 2018 %	Малчин өрхийн тоонд эзлэх хувь			
	2016	2017	2018	2019		2016	2017	2018	2019
Цахилгаантай	12882	12449	12283	12907	105.1	93.4	93.4	82	84.2
Телевизортой	10760	11142	10498	11097	105.7	75.8	75.8	70.1	72.4
Автомашинтай	6258	6580	4477	7123	159.1	33.1	33.1	30	46.5
Мотоциклтой	6823	7009	7594	8306	109.4	47.3	47.3	50.7	54.2
Трактортой	174	214	214	190	88.8	1.2	1.2	1.4	1.2

Сумдаар харуулсан дэлгэрэнгүй мэдээллийг хавсралт 3-д харуулав.

Малчдын соёл, ахуйн нөхцөлийн үзүүлэлт



тодорхойлох зорилгоор 2006 оноос хойш мал тооллоогоор цахилгаан үүсгүүрийг төрлөөр задлан авсан.

Хүснэгт 4

	Бүгд	Үүнээс:				Дүнд эзлэх хувь			
		Нарны	Салхины	Бага оврын цахилгаан	Төвлөрсөн	Нарны	Салхины	Бага оврын цахилгаан	Төвлөрсөн
Цахилгаан үүсгүүртэй өрх	12907	12566	19	23	315	97.4	0.1	0.2	2.4

Нийт цахилгаан үүсгүүртэй өрхийн 97.4 хувь нь нарны, 0.1 хувь нь салхины, 2.4 хувь нь төвлөрсөн цахилгаан эх үүсгүүр хэрэглэж байна.

II.2.2 Мал, тэжээвэр амьтдын тоо, сүргийн бүтэц

Малын тоо. Манай аймгийн малын тоо 2019 оны эцэст 6167.1 мянга болж, 2018 оныхоос 685.1 мянгаар буюу 12.5 хувиар өслөө.

Тооллогын дүнгээр тэмээний тоо 1.4 мянга, адуу 425.9 мянга, үхэр 710.1 мянга, хонь 3321.3 мянга, ямаа 1708.4 мянгад хүрч, 2018 оны тооллогын дүнтэй харьцуулахад мал 5 төрөл бүрд өссөн дүнтэй байна. 2018 онд 339.7 мянган сарлаг тоологдсон нь нийт үхрийн 47.8 хувийг эзэлж байна. Сарлагийн тоо өнгөрсөн оныхоос 21.4 хувиар буюу 59.8 мянган толгойгоор өсчээ. (Хавсралт 3).

Малын тоо /мян.толгойгоор/

Хүснэгт 5


	2015	2016	2017	2018	2019	$\frac{2019}{2018}$ %
Бүгд	4457.1	5009.6	5291.7	5482.0	6167.1	112.5
Тэмээ	1.1	1.2	1.4	1.3	1.4	107.7
Адуу	324.2	356.8	381.1	378.4	425.9	112.6
Үхэр	544.2	581.2	628.8	621.2	710.1	114.3
Хонь	2317	2668.1	2845	2981.8	3321.3	111.4
Ямаа	1270.6	1402.3	1435.4	1499.3	1708.4	113.9

2019 онд нийт малын тоо толгойн 81.6 хувийг бог мал, 11.5 хувийг үхэр, 6.9 хувийг адуу эзэлж байна. Малын тоог сумдаар нь өмнөх онтой харьцуулж үзвэл бүх сумдын малын тоо 2018 оноос өссөн байна.

(Хавсралт 3)

Малын тоо

Зураг 4



Эрдэнэмандал (558.5 мянга), Хайрхан (453.3 мянга), Батцэнгэл (433.7 мянга) сумд малын тоогоороо аймагт тэргүүлээ. (Хавсралт 8).


	2014	2015	2016	2017	2018	2019
Бүгд	100	100	100	100	100	100
Тэмээ	0.02	0.02	0.02	0.03	0.02	0.02
Адуу	7.1	7.3	7.1	7.2	6.9	6.9
Үхэр	11.7	12.2	11.6	11.9	11.3	11.5
Хонь	51.9	52	53.3	53.8	54.4	53.9
Ямаа	29.3	28.5	28	27.1	27.3	27.7

Хүснэгт 6

2018,2019 онуудад аймагт нийт мал болон хонины тоогоор Эрдэнэмандал, адуугаар Цэнхэр, ямаагаар Хотонт, тэмээгээр Хашаат,2018 онд үхрээр Өндөр-Улаан сумдууд жил дарааллан тэргүүлж байна. (Хавсралт 8).


Зураг 5

Нийт сүрэгт таван төрлийн эзлэх хувь



2019 онд улсад нийт малын тоогоороо Архангай /6167.0/, Хөвсгөл /6040.4/, Өвөрхангай /5625.5/, Төв /4979.2/, Хэнтий /4868.4/ зэрэг аймгууд тэргүүлж байна. (Хавсралт 51).

Зураг 6.



Хувийн / амины / малын тоо. 2019 онд хувийн малын тоо 6159.4 мянган толгойд хүрч, нийт малын 99.8 хувийг, аж ахуй нэгжийн мал 7.6 мянга хүр, нийт малын 0.2 хувийг тус тус эзэлж байна. Хувийн малын тоо урьд оноос 12.5 хувиар буюу 685.2 мянгаар өсчээ. (хавсралт 4,5).

Хувийн малтай өрх, тэдгээрийн малын тоо

Хүснэгт 7

	Малтай өрхийн тоо Мян, өрх	Бүгд	үүнээс:				
			Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
2009	18.6	3608.2	0.8	250.8	385.1	1779	1192.5
2010	18.5	2674.4	0.9	196	301.5	1324.6	851.4
2011	17.6	2979.9	0.9	218.6	335.5	1462.1	962.6
2012	17.8	3397.6	1.1	238.5	370.5	1743.8	1043.7
2013	17.1	3766.9	1.1	268.1	426.6	1941.1	1130
2014	17.2	4287.3	1.2	303.8	502.1	2225.9	1254.3
2015	17.4	4449.3	1.1	324.1	543.7	2311.8	1268.6
2016	17.8	4999.5	1.2	356.5	580.5	2661.5	1399.8
2017	18.4	5280.7	1.4	380.7	628	2837.5	1433.1
2018	18.8	5474.2	1.3	378.2	620.8	2976.6	1497.3
2019	19.1	6159.4	1.3	425.8	709.6	3315.9	1706.8

2019 оны байдлаар хувийн аж ахуйд байгаа малын 21.8 хувийг ямаа, 69.8 хувийг хонь, 1.5 хувийг адуу, 6.9 хувийг үхэр эзэлж байна.

Өрхийн малын бүлэглэлт

2019 оны эцэст иргэдийн хувийн малын бүлэглэлтээс авч үзвэл 100 хүртэл толгой малтай өрхийн тоо 5.0 мянга болж, 2018 оныхоос 0.4 мянган өрхөөр буюу 7.4 хувиар буурч, 100 дээш малтай өрхийн тоо 4.0 мянга болж, 2018 оныхоос 0.1 мянган өрхөөр буюу 3.2 хувиар буурсан байна. 2019 онд нийт малтай өрхөд 100 хүртэл толгой малтай өрхийн эзлэх хувийн жин 26.2 болж, 2018 оныхоос 2.6 пунктээр буурч, харин 100-аас дээшхи бүлгийн малтай өрхийн эзлэх хувийн жин 73.8 хувь болж 2.6 пунктээр нэмэгдсэн байна. 2019 оны байдлаар малтай өрхийн 26.2 хувь 100 хүртэл толгой малтай, 21.2 хувь нь 101-200 толгой малтай, 52.6 хувь нь 200-аас дээш толгой малтай байна. (хавсралт 12).

	Хүснэгт 8					
	Малтай өрхийн тоо		Дүнд эзлэх хувь		Малын тоо, мян,тол	
	2018	2019	2018	2019	2018	2019
Дүн	18759	19102	100	100	5482	6159.5
100 хүртэл малтай	5410	5008	28.8	26.2	257.5	242.4
101-200 малтай	4177	4042	22.3	21.2	616.2	599.5
201-500 малтай	5910	6137	31.5	32.1	1891.1	1985.0
501-999 малтай	2414	2814	12.9	14.7	1632.3	1922.9
1000-1499 малтай	713	910	3.8	4.8	816.8	1049.8
1500-2000 малтай	94	135	0.5	0.7	160.6	227.7
2001-ээс дээш малтай	42	56	0.2	0.3	101.1	132.2

Малтай өрхийн малын бүлэглэлт

1000-аас дээш малтай өрх 1101 өрх тоологдсон бөгөөд 2018 оныхоос 264 өрхөөр нэмэгдсэн байна. Сүүлийн 5 жилд хамгийн олон малтай өрхөөр Эрдэнэмандал сумын өрх орж байна.1000-аас дээш малтай өрхийн тоогоор Эрдэнэмандал сум тэргүүлж, удаах байранд Хашаат, Батцэнгэл,Хайрхан сумд 2017,2018,2019 онуудад орж байна. (Хавсралт 13).2019 оны байдлаар амьжиргааны гол эх үүсвэр нь мал аж ахуй болсон малчинөрхийн эзэмшилд нийт малын 99.8 хувь буюу 6159.7 мянган толгой мал байна. (Хавсралт 14).

Малчин өрхийн малын бүлэглэлт

Хүснэгт 9

	Малчин өрхийн		Малын тоо,		үүнээс:				
	2018	2019	2018	2019	ТЭМЭЭ	АДУУ	ҮХЭР	ХОНЬ	ЯМАА
Дүн	14978	15236	4979.6	5595.9	1.1	386.5	628.8	3034.9	1544.6
100 хүртэл малтай	3325	3053	167.8	156.5		14.4	46.8	52.6	42.7
101-200 малтай	3269	3083	485.5	459.9		38.3	89.5	190.5	141.6
201-500 малтай	5216	5320	1683.6	1741		124.0	220.3	858.4	538.3
501-999 малтай	2329	2692	1576.2	1845.8	0.6	114.6	161.0	1058.5	511.1
1000-1499 малтай	704	899	806.4	1036.3	0.4	64.7	81.3	646.4	243.5
1500-2000 малтай	93	133	159	224.25	0.1	17.5	20.4	142.6	43.7
2001-ээс дээш малтай	42	56	101.1	132.1		13.0	9.5	85.9	23.7

2018 оны байдлаар малтай нэг өрхөд дунджаар 292 толгой мал, үүний дотор адуу 20, үхэр 43, хонь 158, ямаа 80 тус тус ногдож байсан. Харин 2019 онд нэг малтай өрхөд дунджаар нийт 322 толгой мал ногдож, үүний дотор адуу 22, үхэр 37, хонь 174, ямаа 89 ногдож байна. 2019 онд малтай нэг өрхөд ногдох малын тоо дунджаар өмнөх оныхоос 30 толгойгоор нэмэгдсэн байна.

Нэг өрхөд ногдох малын бүтцийг авч үзэхэд 81.7 хувь нь бог мал, 18.3 хувь нь бод мал байна.

Мал бүхий өрхийн дүнд дийлэнх хувийг эзэлж байгаа 201-500 хүртэлх толгой малтай нэг өрхөд дунджаар 323 толгой, 501-999 толгой малтай нэг өрхөд дунджаар 683, 1000 ба түүнээс дээш малтай өрхөд 1280 толгой мал тус тус ногдож байна.

Малтай 1 өрхөд ногдох хувийн малын тоо, бүлэглэлтээр

	2017	2018	2019					
			Бүгд	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
Дүн	287	292	322		22	37	174	89
10 хүртэл малтай	7	7	7		1	5	1	0
11-30 хүртэл малтай	21	21	21		2	9	5	5
31-50 хүртэл малтай	41	41	41		4	13	13	11
51-100 хүртэл малтай	75	75	75		7	20	27	21
101-200 малтай	147	148	148		12	28	63	45
201-500 малтай	319	320	323		23	40	161	100
501-999 малтай	675	676	683		43	59	392	189
1000-1499 малтай	1144	1146	1154		72	90	719	272
1500-2000 малтай	1690	1708	1686		131	152	1 074	329
2001-ээс дээш малтай	2423	2407	2361		232	170	1 535	423

2019 оны малтай нэг өрхөд ногдох малын тоог сумдаар авч үзэхэд бүх сумдад өссөн байна. /хавсралт 7/

Хээлтэгч мал. 2019 оны эцэст 2652.1 мянган толгой хээлтэгч мал тоологдсон нь өнгөрсөн оныхоос 286.8 мянган толгойгоор өсч үүний дотор гүү 15.8 мянгаар, үнээ 32.2 мянгаар, эм хонь 154.4 мянгаар, эм ямаа 84.4 мянгаар толгойгоор өссөн байна. (Хавсралт 16).

Хүснэгт 11

Хээлтэгч малын тоо

Мян.тол

	2015	2016	2017	2018	2019	2019/2018	
						хувь	Зөрүү
Бүгд	1905.8	2138.5	2234.2	2365.3	2652.1	112.1	286.8
Ингэ,тол	0.4	0.4	0.5	0.5	0.5	100.0	0.0
Гүү	98.7	109.7	116.2	121.4	137.2	113.0	15.8
Үнээ	205.5	221.3	236.2	239.9	272.1	113.4	32.2
Эм хонь	1042.1	1198	1263	1345.8	1500.2	111.5	154.4
Эм ямаа	559.1	609.1	618.3	657.7	742.1	112.8	84.4

Хээлтэгч мал нь нийт малын 43.0 хувийг эзэлж байгаа бөгөөд тэмээн сүргийн 35.7 хувь, адуун сүргийн 32.2 хувь, үхэр сүргийн 38.3 хувь, хонин сүргийн 45.2, ямаан сүргийн 43.4 хувийг тус тус эзэлж байна.

Ихтамир, Өлзийт, Өгийнуур, Эрдэнэбулган сумдад хээлтэгч ингэний тоо 1-48 аар буурч бусад сумдад хээлтэгч малын тоо өмнөх онтой харьцуулахад 286.8 мянган толгой мал буюу 12.1 хувиар өссөн дүнтэй байгааг хавсралт хүнэгтээс харж болно. (Хавсралт 17).

Зураг 7



Эрдэмтэн, судлаачдын үзэж байгаагаар мал аж ахуйн нөхөн үйлдвэрлэлийг хэвийн хэмжээнд байлгахад бод малын хувьд хээлтэгч мал сүргийн 50.0-55.0 хувь, бог малын хувьд сүргийн 60.0-65.0 хувийг эзэлж байвал зохимжтой гэж үздэг байна. Сүүлийн 10 жилийн байдлаар сүрэгт хээлтэгч малын эзлэх хувь бод малд дунджаар 45.9 хувь, бог малд 40.6 хувь байна.

Төл бойжилт. 2019 онд гарсан төлийн 96.5 хувь буюу 1964.7 мянган төл бойжуулав. Бойжсон төлийн тоо 2018 оныхоос 381.7 мянган толгойгоор өсчээ. Ботго 100.0 хувь, унаганы 94.1 хувь, тугалны 96.5 хувь хурганы 97.0 хувь, ишигний 95.5 хувь бойжуулсан байна.

Хүснэгт 12

	Бүгд			үүнээс				
	2016	2017	2019	ботго	унага	тугал	хурга	Ишиг
Гарсан төл	1904	1736	2036.5	0.3	98.9	191.7	1186	559.6
Бойжсон төл	1796.7	1583.0	1964.7	0.3	94.1	184.9	1150.8	534.6
Бойжилтийн хувь	94.4	94.4	96.5	100.0	95.1	96.5	97.0	95.5

Төл бойжилтын хувийг сумдаар авч үзвэл Өгийнуур, Төвшрүүлэх сумд гарсан төлийг 100.0 хувь бойжуулж бусад сумд 87.4-99.6 хувиар төлөө бойжуулсаныг хархад цаг агаарын хүндрэл багатай байсан тул төл бойжилт сайн байгааг харуулж байна. (Хавсралт 19).

Бойжуулсан төлийн тоо 2018 оноосоо тугал 23.6 мянгаар, унага 25.6 мянгаар, ботго 58 толгойгоор, хурга 196.4 мянгаар, ишиг 134.2 мянган толгойгоор өссөн байна.


Хүснэгт 13

	2013	2014	2015	2016	2017	2018	2019
Бүгд	1270.2	1374	1526.6	1592.5	1904	1582.7	1964.7
Ботго	0.2	0.2	0.3	0.3	0.3	0.3	0.3
Унага	58.9	61.6	72.3	73.4	91	70.5	94.1
Тугал	118.2	126.7	155.6	156.1	182.9	159.3	184.9
Хурга	694.5	763.6	863.8	902.7	1090.9	954.4	1150.8
Ишиг	398.4	421.9	434.6	460	538.9	398.4	534.6

Аймгийн дунджаар 100 эхээс 83 төл бойжуулж, 100 эхээс бойжуулсан төлийн тоо 2018 оноос 12-аас өссөн байна.үх төрөл дээрээ буурсан байна.100 эхээс бойжуулсан төлийн тоо урьд оноосоо Ихтамир \3\, Цэнхэр \3\, Өндөрүлаан \2\,Цахир \3\, Хангай \1\, Жаргалант \7\ сумд толгойгоор буурч, харин бусад сумдад 2-36 толгойгоор өссөн байна.

(Хавсралт 20).

Зураг 8



Сумдаас Чулуут, Хайрхан, Өлзийт, Эрдэнэмандал, Хотонт сумд 100 эхээс хамгийн олон төл бойжууллаа.

Хүснэгт 14

100 эхээс бойжуулсан төл

	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019
Бүгд	76	87	85	83	86	84	71	83
Ботго	55	49	58	64	72	69	59	67
Унага	73	81	75	79	80	79	61	78
Тугал	74	82	78	82	83	78	67	77
Хурга	77	88	88	86	89	87	76	86
Ишиг	75	87	84	79	83	82	67	81

Том малын зүй бүсын хорогдол. 2019 онд нийт 63.7 мянган мал хоргсоны дотор адуу 4.1 мянга, үхэр 7.2 мянга, хонь 35.3 мянга, ямаа 17.1 мянган мал тус тус хорогдсон байна. Нийт малын хорогдол нь оны эхний малын 1.2 хувийг эзлэж байгаа өнгөрсөн оныхоос 255.7 мянган мал буюу 19.9 хувиар буурсан байна.

Нийт хорогдсон малын 26.8 хувийг ямаа, 55.4 хувийг хонь, 11.3 хувийг үхэр, 6.4 хувийг адуу эзэлж байна.

Том малын зүй бус хорогдол, мян.толгой


Хүснэгт 15

	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019
Бүгд	59.7	196.1	94.1	100.3	147.4	129.5	319.4	63.7
Тэмээ	-	-	-	-	-	-	-	-
Адуу	3.2	12.3	9.1	6.6	8.3	7.6	31.8	4.1
Үхэр	9.3	18.1	11.3	10.5	42.6	14.1	58.8	7.2
Хонь	27.7	105.2	41.5	52.4	62	65.4	134.1	35.3
Ямаа	19.5	60.5	32.2	30.8	34.5	42.4	94.6	17.1

Нийт хорогдсон малын 8.2 мянга нь өвчнөөр хорогдож, хээлтэгч мал 13.2 мянга хорогдсон байна. Урьд оноосоо өвчнөөр хорогдол мал 1.8 мянгаар буюу 18.4 хувиар бага байна. (Хавсралт 21).

Зураг 9

Том малын зүй бус хорогдол



Хүснэгт 16

	2014	2015	2016	2017	2018	2019
Бүгд	2.5	2.3	3.4	2.6	6.4	6.8
Тэмээ	0.8	0.2	0.8	0.4	6	7.3
Адуу	3.4	2.2	2.7	2	8.9	6.7
Үхэр	2.6	2.1	8.5	2.2	10.1	7.5
Хонь	2.1	2.4	2.8	2.3	5	6.3
Ямаа	2.8	2.5	2.7	3	6.7	7.6

Малын хээл, хаялт, сувайралт. 2019 онд оны эхний хээлтэгч малын 17.8хувь буюу 420.2мянган мал хээл хаяж, сувайрсны улмаас төл өгөөгүй байна. Төл өгөөгүй хээлтэгч малын тоо 2018 оныхоос 16.3 хувиар буюу 82.1 мянгаар буурсан байна. Төл өгөөгүй хээлтэгч малын 76.4 хувь буюу 321.2 мянга нь сувайрсан хээлтэгч, 23.5 хувь буюу 99.0 мянга нь хээл хаясан хээлтэгч мал байна.
(Хавсралт 22,23, 24)

Хүснэгт 17

Хээл хаяж, сувайрсан эх малын тоо, мян.толгой

	Төл өгөөгүй хээлтэгч			Сувайрсан			Хээл хаясан		
	2017	2018	2019	2017	2018	2019	2017	2018	2019
Бүгд	290.1	502.3	420.2	214.8	379.8	321.2	75.3	121.0	99.0
Ингэ	-	-	0.1	-	0.1	0.1	-	-	-
Гүү	20.1	39.4	28.5	15.4	30.3	23.2	4.8	9.1	5.3
Үнээ	40.6	61.1	53.1	30.3	47.3	41.6	10	12.7	11.5
Эм хонь	139.6	235	208.3	104	184	163	35.6	51.4	45.6
Эм ямаа	89.8	166.8	130.2	65	119	93.6	24.9	47.8	36.6

Төл өгөөгүй хээлтэгчийнг төрлөөр нь авч үзвэл ингэ 20.0 хувь, гүү 20.8 хувь, үнээ 19.5 хувь, эм хонь 8.7 хувь, эм ямаа 17.5 хувийг тус бүр эзлэж байна.

Хүснэгт 18

	Төл өгөөгүй хээлтэгч			Сувайрсан			Хээл хаясан		
	2017	2018	2019	2017	2018	2019	2017	2018	2019
Бүгд	15.2	26.4	15.8	10.0	17.8	12.1	3.5	5.7	3.7
Ингэ	-	-	20.0	-	-	20.0	-	-	0.0
Гүү	20.3	39.9	20.8	14.0	27.6	16.9	4.3	8.3	3.9
Үнээ	19.8	29.7	19.5	13.7	21.4	15.3	4.5	5.7	4.2
Эм хонь	13.4	22.6	13.9	8.7	15.3	10.8	3.0	4.3	3.0
Эм ямаа	16.1	29.8	17.5	10.7	19.5	12.6	4.1	7.9	4.9

Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо. Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо нь бод малын хувьд нормоор, харин бог малын хувьд алдагдсан хэвээр байна.2019 онд 48.7 мянган хээлтүүлэгч мал тоологдож, 2018 оныхоос 17.7 хувиар буюу 7.3 мянгаар өссөн байна. Буурны тоо өмнөх онтой харьцуулахад 4 толгойгоор буурч харин азарганы тоо 1.1 мянгаар, бухны тоо 1.7 мянгаар , хуцны тоо 2.6 мянгаар, ухны тоо 1.9 мянган толгойгоор өмнөх оноосоо өссөн байна.

Хүснэгт 19

	Хээлтүүлэгч мал - бүгд					үүнээс: шинээр тавьсан				
	2015	2016	2017	2018	2019	2015	2016	2017	2018	2019
Бүгд	37413	40673	42279	41350	48684	124	59	73	81	241
Буур	14	16	20	21	17		-	-	-	
Азарга	10224	10940	11333	11474	12583	19	25	40	21	6
Бух	7773	8409	9045	8540	10229	19	17	17	30	21
Хуц	11992	13411	13947	13575	16180	57	10	14	26	51
Ухна	7410	7897	7934	7746	9675	29	7	2	4	163

Үржлийн нормоор бог малын нэг хээлтүүлэгчид 25-30 хээлтэгч ногдох ёстой байхад 2018 онд аймгийн дунджаар нэг хуцанд 51 эм хонь, нэг ухнад 163 эм ямаа ногдож байгаа нь нормоос хэтэрсэнийг харуулж байгаа тул нарийн малын хээлтүүлэгч нэмэх шаардалагатайг харж болох юм. (Хавсралт 25).

Хүснэгт 20

	Үржлийн Норм	2014	2015	2016	2017	2018	2019
Ингэ	20-25	24	28	28	25	35	28
Гүү	12-15	10	10	10	10	11	11
Үнээ	35-45	25	26	26	26	28	27
Эм хонь	25-30	84	87	89	91	99	93
Эм ямаа	25-30	71	75	77	78	85	77

Малын хэрэглээний зарлага. 2019 онд оны эхний нийт малын 19.7 хувь буюу 1215.7 мянган малыг хэрэглээнд зарцуулсны дотор үхэр 88.8 мянга, адуу 42.5 мянга, хонь 776.0 мянга, ямаа 308.4 мянгыг хэрэглээнд зарцуулсан байна.

Малтай нэг өрх дунджаар 64 толгой малыг хэрэглээнд зориулан зарцуулсан байна. Үүнийг аймгийн хэмжээний нийт өрхөд оногдуулбал нэг өрхөд дунджаар 45 мал буюу 5 бод, 40 богийг хэрэглээндээ зарцуулсан байна.
(Хавсралт 26,27).

Малын хэрэглээний зарлага

Хүснэгт 21

	2015	2016	2017	2018	2019
Бүгд	1270.1	892.8	1385.1	1136.8	1215.7

Тэмээ	0.3	0.1	0.1	0.2	
Адуу	45.5	32.4	54.2	41.4	42.5
Үхэр	104.1	76.5	111.6	107.9	88.8
Хонь	729.1	489.9	797.2	683.6	776.0
Ямаа	391.1	293.9	422	303.7	308.4
Оны эхний малд эзлэх хувь					
Бүгд	20.1	29.6	20	27.6	19.7
Тэмээ	11.3	0.2	0.1	8.7	0.0
Адуу	6.3	15	10	15.2	10.0
Үхэр	9.4	20.7	14.1	19.2	12.5
Хонь	22.5	32.7	21.1	29.9	23.4
Ямаа	23.4	31.1	23.1	30.1	18.1

Хэрэглээнд зарцуулсан малын 89.2 хувийг бог мал, 10.3 хувийг бод мал эзэлж байгаа бөгөөд оны эхний адууны 10.9 хувь, үхрийн 17.4 хувь, хонины 22.9 хувь, ямааны 20.3 хувийг хэрэглээнд зарцуулсан байна.

Хүснэгт 22

Зах зээлд худалдан борлуулсан болон аж ахуйн дотоодод


хэрэглэсэн малын тоо

	Зах зээлд худалдан борлуулсан					Хүнсэнд хэрэглэсэн				
	2015	2016	2017	2018	2019	2015	2016	2017	2018	2019
Бүгд	736.4	634.6	1097.6	992.7	1281.3	209.4	193.4	221.7	198.8	223.3
Тэмээ	0.1	0.1	0.2	0.3	0.2	-	-	-	-	-
Адуу	32.3	31.6	55.5	51.6	65.8	10.4	9.5	11.4	10.9	10.7
Үхэр	63.3	59.9	101.4	104.5	113.1	19.1	18.9	21.4	21.3	20.1
Хонь	428.4	350.8	623.8	591.6	768.7	103.8	94.0	110.5	103.5	118.9
Ямаа	212.3	192.2	316.7	244.7	333.5	76.1	71.0	78.4	63.1	73.6

Хэрэглээнд зарцуулсан малын 85.2 хувийг зах зээлд худалдан борлуулж, 14.9 хувийг хүнсэнд зарцуулсан байна.

Малтай нэг өрх дунджаар 67 толгой малыг зах зээлд борлуулж, 12 толгой малыг өөрийн хүнсэндээ хэрэглэсэн байна.

Зураг 10



Сүргийн бүтэц. 2019 оны байдлаар нийт сүргийн 33.2 хувь буюу 2049.5 мянган толгой нь төл, өсвөр насны мал, 23.0 хувь буюу 1416.7 мянган толгой нь нас гүйцсэн мал, 43.0 хувь буюу 2652.1 мянган толгой нь хээлтэгч мал, 0.8 хувь буюу 48.7 мянга нь хээлтүүлэгч мал байна. (Хавсралт 29-34).

Хүснэгт 23

	Толгойгоор, мян,тол					Хувиар				
	Бүгд	Төл, өсвөр насны мал	Нас гүйцсэн эр мал	хээлтэгч	Хээлтүүлэгч	Бүгд	Төл, өсвөр насны мал	Нас гүйцсэн эр мал	Хээлтэгч	Хээлтүүлэгч
Бүгд	6167.0	2049.5	1416.7	2652.1	48.7	100.0	33.2	23.0	43.0	0.8
Тэмээ	1.3	0.6	0.2	0.5	0.0	100.0	45.5	15.2	37.9	1.5
Адуу	425.9	187.9	88.2	137.2	12.6	100.0	44.1	20.7	32.2	3.0
Үхэр	710.1	300.1	127.7	272.1	10.2	100.0	42.3	18.0	38.3	1.4
Хонь	3321.3	1068.0	736.9	1500.2	16.2	100.0	32.2	22.2	45.2	0.5
Ямаа	1708.4	492.9	463.7	742.1	9.7	100.0	28.9	27.1	43.4	0.6

Хүснэгт 24

Сүргийн бүтэц, хувиар

	Төл, өсвөр насны					Нас гүйцсэн эр				
	2015	2016	2017	2018	2019	2015	2016	2017	2018	2019
Бүгд	34.8	32.3	33.4	31.2	33.2	21.6	24.2	23.6	24.9	23.0
Тэмээ	42.5	30.5	43.3	43.3	45.5	17.9	32.5	19.8	14.1	15.2
Адуу	44	32.5	44.6	41.4	44.1	22.4	33.6	21.9	23.5	20.7
Үхэр	42.9	41.1	42.8	41.3	42.3	17.9	19.4	18.1	18.7	18.0
Хонь	33.8	31.6	31.7	30.5	32.2	20.7	23	23.4	23.9	22.2
Ямаа	30.3	29.9	29.7	25.7	28.9	24.7	26.1	26.7	29.9	27.1

Үргэлжлэл

	Хээлтэгч					Хээлтүүлэгч				
	2015	2016	2017	2018	2019	2015	2016	2017	2018	2019
Бүгд	42.8	38	42.2	43.1	43.0	0.8	0.8	0.8	0.8	0.8
Тэмээ	38.3	35.8	35.4	41.4	37.9	1.3	1.3	1.4	1.2	1.5
Адуу	30.5	30.7	32.5	32.1	32.2	3.2	3.1	3	3	3.0
Үхэр	37.8	38.1	37.6	38.6	38.3	1.4	1.4	1.4	1.4	1.4
Хонь	45	44.9	44.4	45.1	45.2	0.5	0.5	0.5	0.5	0.5
Ямаа	44.2	43.4	43.1	43.9	43.4	0.8	0.6	0.6	0.5	0.6

Нийт сүрэгт эзлэх хувийн жин 2019 онтой харьцуулахад нас гүйцсэн малынх ингэнээс бусад төрөл дээр өсч, төл, өсвөр насны мал бүх төрөл дээрээ буурч, хээлтэгч ингэнээс бусад төрөл дээрээ өсч, хээлтүүлэгч эм ямаа, ингэ буурч, бусад төрөл дээрээ өмнөх онтойгоо ижил түвшинд байна.

Зураг 11



Цэвэр үүлдрийн болон эрлийз, нутгийн шилдэг омгийн мал. 2019 оны эцэст цэвэр үүлдрийн 21.3 мянган мал тоологдов.

2018 онтой харьцуулахад цэвэр үүлдрийн хонь 21.3 мянган толгойгоор өссөн байна.

	2015	2016	2017	2018	2019	2019/2018	
						Хувь	зөрүү
Цэвэр үүлдрийн мал							
Үхэр	0.6	0.6	0.6	0.6	0.5	83	-0.1
Хонь	9	9.7	7.8	2.2	20.8	945	18.6
Дүн	9.6	10.3	8.4	2.8	21.3	761	18.5

Ш.2.3 МАЛЫН БЭЛЧЭЭР, ТЭЖЭЭЛИЙН ХҮРЭЛЦЭЭ,ХАНГАМЖ

Бэлчээрийн хүрэлцээ. Манай аймгийн Газрын албаны 2017 оны газрын нэгдмэл сангийн тайлангаар бэлчээрийн хадлангийн талбай 3744.1 мянган га талбайтай байна.

2019 онд 100 га хадлан, бэлчээрийн талбайд хонин толгойд шилжүүлснээр 365 толгой мал ногдож байна.


Бэлчээрийн хүрэлцээ хангамж

	2015	2016	2017	2018	2019	2019/2018	
						хувь	зөрүү
Хадлан бэлчээрийн талбай мян,га	3744.2	3744.2	3744.1	3744.1	3744.1	100	-
100 га хадлан, бэлчээрийн талбайд ногдох хонин толгойд Шилжүүлсэн малын тоо	247	265	283	365	365	129	82

100 га хадлан, бэлчээрийн талбайд ногдох хонин толгойд шилжүүлсэн малын тоо 2019 онд өмнөх онтой ижил түвшинл байна. (Хавсралт 37).

**100 га хадлан, бэлчээрийн талбайд ногдох хонин толгойд
шилжиүүлсэн малын тоо**

Зураг 12



Малын тэжээлийн үйлдвэрлэлт, хангамж. 2019 онд аймгийн хэмжээгээр нийт 74771.0 тн хадлан бэлтгэсэн нь өмнөх оноос 3984 тн оор илүү бэлтгэсэн байна. Нийт бэлтгэсэн тэжээлийн 88.2 хувийг, хужир шүү 1.8 хувийг, 3.5 тэжээлийн ургамал, гаргэжээл 1.5 хувийг эзэлж байна.
(Хавсралт 38,39)


Хүснэгт 27

	2015	2016	2017	2018	2019	2019
						2018
Байгалийн хадлан	71830.0	84605.0	50523.0	70787.0	74771.0	105.6
Гар тэжээл	1541.0	1292.3	952.2	1155.0	1192.0	103.2
Тэжээлийн ургамал	4532.5	4661.0	96.0	265.1	2814.2	1061.6
Хужир шүү	86.2	277.3	280.1	325.8	1449.0	444.8
Үйлдвэрлэсэн тэжээл						
Бүгд (тэжээл нэгж)	35537.1	41272.8	24006.0	33430.7	80226.2	240.0

Бэлтгэвэл зохих хадлангаа Эрдэнэбулган, Жаргалант, Булган, Ихтамир, Хотонт, Цахир, Чулуут, Эрдэнэмандал сумдууд 100-115 хувиар биелүүлж, бусад бүх сумд 7.3-65.9 хувиар биелүүлээгүй байна.

Зураг 13

Бэлтгэсэн хадлан, мян, тн



II.2.4 ТЭЖЭЭВЭР АМЬТАД

2019 онд 226 гахай, 34 шувуу тоологдсон нь 2017 оныхоос 59 гахай толгойгоор нэмэгдэж, шувуу 46 толгойгоор буурч, гахайтай өрхийн тоо өмнөх оноос өөрчлөгдөөгүй, шувуутай өрхийн тоо 2-оор буурсан байна. (Хавсралт 40).

	2014	2015	2016	2017	2018	Хүснэгт 28	
						2019	$\frac{2019}{2018}$ %
Гахай	371	353	174	209	167	226	135.3
Шувуу	149	136	61	68	80	34	42.5
Гахайтай өрхийн тоо	56	45	8	10	6	6	100.0
Шувуутай өрхийн тоо	5	3	3	5	6	4	66.7

II.2.5 ХУДАГ, УСАН САНГИЙН ТООЛЛОГО

Худаг,усан сан. ҮСХ-оос хашаа, худаг уст цэгийн тооллогыг 3 жил тутамд мал тооллоготой хамт явуулж байна. 2018 оны мал тооллоготой хамт худаг, усан сангийн тооллогыг явуулж үр дүнг нэгтгэн гаргалаа. 2018 онд нийт 681 ширхэг худаг, 7 ширхэг усан сан тоологдлоо.

Тоологдсон худгийн 593 ширхэг нь инженерийн хийцтэй, 88 ширхэг нь энгийн худаг байна. Нийт худагаас 330 ширхэг буюу 48.6 хувь нь малын бэлчээрт байршиж байна. (Хавсралт 41).

Хүснэгт 29

Худаг,усан сангийн тоо					
	2006	2009	2012	2015	2018
Худаг-бүгд	1088	963	436	665	681
үүнээс:					
Инженерийн	940	476	322	574	593
Энгийн	148	487	114	91	88
Бэлчээрт байршдаг	631	540	315	249	330
Ашиглагддаггүй	389	303	41	23	16
Усан сан	17	11	5	5	7
Багтаамж	37.4	26.0	12.0	12.0	13.0

II.2.6 Шинээр гаргасан, засварласан худаг

Монгол Улсын Засгийн газраас усны нөөцийн эх үүсвэрийг зохистой ашиглах замаар хүн ам, малын усны хангамжийг нэмэгдүүлэх, бэлчээрийн ашиглалтыг сайжруулахад анхаарал хандуулж, худаг, уст цэгийг шинээр гаргах, сэргээн засварлахад зориулан тодорхой хэмжээний хөрөнгө зарцуулж байна.

Хүснэгт 30

2019 онд шинээр гаргасан худгийн тайлан,мянган төгрөг						
Шинээр гаргасан худгийн тоо, бүгд	үүнээс:			үүнээс:		
	инженерийн хийцтэй	энгийн уурхай	Шинээр худаг гаргахад зарцуулсан хөрөнгийн	Улсын төсвийн хөрөнгөөр, сая,төг	олон улсын байгууллагын төсөл хөтөлбөрийн	Бусад ,сая,төг
ДҮН	13	13	187838.0	131358.0	56480.0	

2019 онд 13 худаг шинээр ашиглалтанд орсноос 13 инженерийн худаг байна.

Шинээр худаг гаргахад нийт 187838.0 сая төгрөг зарцуулсны 70.0 хувь улсын төсвийн хөрөнгөөр,30.0 хувь нь гадаад орон,олон улсын байгууллагын хөрөнгөөр санхүүжигдсэн байна. (Хавсралт 47)

Хүснэгт 31

2019 онд засварласан худгийн тайлан

	Засварласан худгийн тоо, бүгд	үүнээс:		Хуудлаг засварлахад зарцуулсан хөрөнгийн хэмжээ, мян.төг	үүнээс:		
		инженерийн хийцтэй	энгийн уурхай		Улсын төсвийн хөрөнгөөр, сая,төг	олон улсын байгууллагын төсөл	хөтөлбөрийн
ДҮН	6	6		4400.0	4400.0	-	-

2019 онд нийт 6 худаг засварласнаас бүгд инженерийн хийцтэй, худгийн засвар шинэчлэлд нийт 4.4 сая төгрөг зарцуулсан байна.
(Хавсралт 48).

II.2.7 МАЛЫН ХАШАА,БАГТААМЖ

Малын хашаа,багтаамж. 2018 онд 6812.7 мянган толгой багтаамж бүхий 24.8 мянган ширхэг хашаа тоологдов. Үүний 69.4 хувь саравчтай байр, 30.6 хувь саравчгүй энгийн хашаа байгаа юм. 2018 онд хашаажилтын 17.3 хувь бод малд , бог малд 82.7 хувь нь байна. (Хавсралт 42,43).

Хүснэгт 32

Малын хашааны тоо, багтаамж, төрлөөр

	Хашаа-тоо, багтаамж мян,тол						
	2009	2012	2015	2018	2015/2018		
					Хувь	зөрүү	
Хашаа-бүгд	11506	18023	24056	24807	103.1	751	
Багтаамж	2366.4	6184.8	6771.4	6812.7	100.6	41.3	
Саравчтай хашаа	10149	13244	15435	17239	111.7	1804	
Багтаамж	2477.4	4388.5	4293.4	4943.6	115.1	650.2	
Саравчгүй хашаа	3139	3701	4844	6817	140.7	1973	
Багтаамж	836.1	1444.3	1304.8	1869.1	143.2	564.3	
Нийт хашаанаас							
бодын хашаа	5290	3849	3777	2527	66.9	-1250	
Багтаамж	294.9	781.1	534.9	567.1	106.2	32.2	
Бодын хашааны хангамж	76.5	210.4	220.1	165.5	75.2	-54.6	
Богийн хашааны хангамж	101.3	193.5	187.6	155.6	82.9	-32.0	

II.3 Мал эмнэлгийн үйлчилгээ

ХХААЖижиг дунд үйлдвэрийн газрын Мал эмнэлэгийн албаны мэдээгээр 2019 онд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд давхардсан тоогоор 1454.6 мянган толгой мал хамрагдаж, 480.4 сая төгрөгийн зардал, лабораторийн оношлогоо, шинжилгээнд давхардсан тоогоор 23.5 мянган толгой мал хамрагдаж, 9.4 сая төгрөгийн зардал гарсан байна. (Хавсралт 49)

Мал эмнэлгийн арга хэмжээний мэдээ

Хүснэгт 33

	Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ			Лабораторийн оношилгоо, шинжилгээ			Гоц халдварт өвчний вакцинжуулалтын зардал		
	Хамрагдсан малын тоо, мян.тол	Зарцуулсан зардал, сая төг	1 малд ногдох зардал, төг	Хамрагдсан малын тоо, мян.тол	Зарцуулсан зардал, сая төг	1 малд ногдох зардал, төг	Хамрагдсан малын тоо, мян.тол	Зарцуулсан зардал, сая төг	1 малд ногдох зардал, төг
2016	1165.0	215.5	185	22.5	5.4	240	13.6	694.7	150
2017	1136.0	480.7	187	22.0	7.8	240	1740.3	11064 2.0	150
2018	112.6	21.1	187	25.6	12.0	240	1687.7	29184 5.9	150
2019	1454.6	480.4	330.4	23.5	9.4	398.4	0	29184 0	0

Тайлбар:Гоц халдварт вакцинжуулалтын зардал 2016 оноос хийгдсэн.

III. ГАЗАР ТАРИАЛАН

III.1 Тариалсан талбай

Тариалсан талбай. Аймгийн хэмжээгээр 2019 онд нийт 11845.0 га-д тариалалт хийсэн нь 2018 оныхоос 2417.2 мянган га-аар буюу 25.6 хувиар буурсан байна.

Тариалсан талбай, га-гаар

	2015	2016	2017	2018	2019	2019/2018	
						хувь	Зөрүү
Нийт тариалсан талбай	6296.9	7131.4	10107.2	9427.8	11845.0	125.6	2417.2
Үр тариа	4211.0	5076.0	7710.0	6913.1	9040.0	130.8	2126.9
Үүнээс: Буудай	4207.0	5002.0	7560.0	6265.0	8915.0	142.3	2650.0
Төмс	470.9	459.8	479.6	252.4	264.3	104.7	11.9
Хүнсний ногоо	158.0	155.2	171.9	104.6	126.5	120.9	21.9
Тэжээлийн ургамал	1457.0	1440.4	1745.7	2155.0	2414.2	112.0	259.2

2019 онд тариалсан талбайг ургамлын нэр төрлөөр авч үзвэл: 9.0 мян.га-д үр тариа, улаан буудай 8.9 мянган га-д, 0.3 мян.га-д төмс, 0.1 мян.га-д хүнсний ногоо, 2.2 мян.га-д тэжээлийн ургамал тариалсан нь нийт тариалсан талбай 2017 оныхоос үр тариа 2126.9 га-аар ,улаан буудай 2650 га-аар,хүнсний ногоо 21.9 га-аар,төмс 21.9 га-аар тэжээлийн ургамал 259.2 га-гаар нэмэгдсэн байна.

(Хавсралт 53).

III.2 Хураасан ургац

Манай аймаг 2018 онд 6639.5 тн үр тариа, 2113.8 тн төмс, 477.8 тн хүнсний ногоо хурааж, 70785 тн өвс хадлан, 1155.3 тн гар тэжээл бэлтгэсэн нь 2017 оныхоос үр тариа 1.9 мянган тн-оор буюу 5069 хувиар ,хадлан 19.8 мянган тн-оор буюу 38.9 хувиар нэмэгдэж,, төмс 0.4 мянган тн-оор буюу 15.7 хувиар, хүнсний ногоо 0.3 мянган тн-оор буюу 36.6 хувиар,

тэжээлийн ургамал 76 тн-оор буюу 1.3 хувиар бага байна.

Хураасан ургац /тонноор/

Хүснэгт 35

	2015	2016	2017	2018	2019	2019/2018	
						хувь	зөрүү
Үр тариа	2676.2	7310	4401	6639.5	10692.0	161.0	4052.5
Үүнээс: Буудай	2660.2	7206	4308	6232	10607	170.2	4375.0
Төмс	3538.5	3531.6	2507.7	2113.8	2462.1	116.5	348.3
Хүнсний ногоо	1291.2	1191.1	754	477.8	1226.2	256.6	748.4
Хадлан	71830	84605	50971	70785	74883	105.8	4097.9
Тэжээлийн ургамал	4532.5	4661	5893	5817	1097.9	18.9	-4719.1

III.3 ГА-ГИЙН УРГАЦ

2018 онд нэг га-гаас дунджаар 11.8 цн буудай , 93.2 цн төмс, 96.9 цн хүнсний ногоо хураан авсан бөгөөд нэг га-гаас авсан ургац урьд оноосоо улаан буудай 4.0 цн-ээр,хүнсний ногоо 5 цн-ээр ,төмс 32 цн-ээр нэмэгдсэн байна. (Хавсралт 52).

Га-гийн ургац, центнер

Хүснэгт 36

Төрөл	2015	2016	2017	2018	2019
Үр тариа-дундаж	6	14	6	10	11.8
Улаан буудай	6	14	6	10	11.8
Төмс	75	77	52	84	93.2
Хүнсний ногоо	71	74	44	49	96.9

III.4 ХӨДӨӨ АЖ АХУЙН ЭДЭЛБЭР ГАЗАР

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын мэдээгээр 2019 онд хөдөө аж ахуйн эдэлбэр газрын хэмжээ 3855.7 мянган га байна.

Хөдөө аж ахуйн эдэлбэр газрын 97.1 хувийг бэлчээрийн талбай, 1.3 хувийг хадлангийн талбай, 0.5 хувийг тариалангийн талбай, 1.1 хувийг атаржсан газар эзэлж байна.

ХАА-н эдэлбэр газар, мян.га

Хүснэгт 37

	2014	2015	2016	2017	2018	2019
Хөдөө аж ахуйн эдэлбэр газар	3856.0	3856.0	3856.0	3856.0	3855.7	3855.7
- Бэлчээр	3744.1	3744.1	3744.1	3744.1	3742.8	3742.8
- Хадлан	53.9	53.9	53.9	53.9	53.9	53.9
- Тариалан	18.9	18.9	18.9	18.9	23.3	23.3
- Атаржсан газар	38.3	38.3	38.3	38.3	33.8	33.8
- ХАА-н бусад хэрэгцээний газар	0.8	0.8	0.8	0.8	1.9	1.9

ДҮГНЭЛТ

2019 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр малын тоо 6167.0 мянган толгой болж, өмнөх оныхоос 685.0 мянгаар буюу 12.5 хувиар өслөө.

Өмнөх оноосоо малыг төрлөөр авч үзвэл тэмээ 107 толгойгоор, адуу 47.5 мянган толгойгоор, үхэр 88.8 мянган толгойгоор, хонь 339.5 мянган толгойгоор, ямаа 209.1 мянган толгойгоор өссөн байна.

2019 онд 109.9 мянган литр сүү, 2.9 мянган тонн хонины ноос, 0.5 мянган тонн ноолуур, 4.3 кг тэмээний ноос, 255.2 мянган ширхэг арьс, шир үйлдвэрлэв. Өмнөх оныхтой харьцуулахад сүүний үйлдвэрлэл 20.1 мянган литрээр, ямааны ноолуур 61.5 тонн, бодын хөөвөр 13.2 тонн, бодын хялгас 7.3 тонноор өсч, харин арьс, шир 103.3 мянган ширхгээр, хонины ноос 0.8 мянган тонноор буурсан байна.

Малтай өрх 19102 байгаа ба үүний 79.7 хувь буюу 15236 нь малчин өрх байна. 2018 оныхоос малтай өрх 1.8 хувиар буюу 343 өрхөөр, малчин өрх 1.7 хувиар буюу 258 өрхөөр өссөн байна. Малчдын тоо 25688 болж өмнөх оноос 0.06 хувиар буюу 16 өрхөөр буурсан байна.

Нийт малчдын 32.3 хувь нь 16-34 насны, 55.6 хувь нь 35-59 насны, 12.1 хувь нь 60 болон түүнээс дээш насны малчид байна. Аймгийн нэг малтай өрхөд 322 толгой мал, нэг малчин өрхөд 368 толгой мал ноогдож байна. Малын тоо бүх сумдад 8.6-16.6 хувиар өссөн байна.

Эрдэнмандал сум 127 мянгат малчны тоогоор тэргүүлж, Хайрхан сум 109 мянгат малчинтайгаар хоёрдугаарт, Хашаат 102 сум мянгат малчинтайгаар гуравдугаарт орж байна. Аймгийн хэмжээнд 2000 аас дээш мал тоолуулсан 56 байна. Нийт малчин өрхийн 1.6 хувь буюу 242 нь 10 хүртэл малтай, 4.2 хувь буюу 650 өрх 11-30 хүртэл малтай, 4.2 хувь буюу 636 өрх 31-50 хүртэл малтай, 10.0 хувь буюу 1525 өрх нь 51-100 хүртэл малтай, 20.2 хувь буюу 3083 өрх 101-200 малтай, 34.9 хувь буюу 5320 өрх 201-500 малтай, 17.7 хувь буюу 2692 өрх 501-999 малтай, 5.9 хувь буюу 899 өрх 1000-1499 малтай, 0.9 хувь буюу 133 өрх 1500-2000 малтай, 0.4 хувь буюу 56 өрх 2000-аас дээш малтай байна.

2019 оны мал тоологдоор нийт малчин өрхийн 84.2 хувь нь цахилгааны эх үүсгүүртэй, 72.4 хувь нь телевизортой, 46.5 хувь нь авто машинтай, 54.2 хувь нь мотоцикльтай, 1.2 хувь нь трактортой байна.

Оны эхэнд тоологдсон нийт малын 1.2 хувь буюу 63.7 мянган толгой мал зүй бусаар хорогдсон ба хорогдлын 82.2 хувийг бог мал эзэлж байна. Хорогдсон малын 12.8 хувь буюу 8.2 мянган толгой нь өвчнөөр хорогдсон байна.

Нийт 48684 толгой хээлтүүлэгчийн 53.1 хувийг хуц, ухна эзэлж байна. Нэг хээлтүүлэгчид 5 төрөл дээр 28 ингэ, 11 гүү, 27 үнээ, 93 эм хонь, 77 эм ямаа ногдож байгаа нь үржлийн нормт хэмжээнээс гүү, үнээ нормын түвшинд, ингэ, эм хонь, эм ямаа нормоос өндөр байна.

2019 оны байдлаар нийт мал сүргийн 81.6 хувийг бог мал, 18.4 хувийг бод мал эзэлж байгаа нь урд оны түвшинд байна. Бог малын дотор хонь 66.0 хувь, ямаа 34.4 хувийг эзэлж байна

Сүргийн бүтцийн уламжлалт харьцаа сүүлийн жилүүдэд ихээхэн хэмжээгээр алдагдсаар байгаа. 2010 онд нийт мал сүргийн 40.5 хувь нь хорогдож, сүргийн бүтцийн харьцаа ихээхэн алдагдсан хэдий ч сүүлийн жилүүдэд сүргийн бүтцийн харьцаанд эерэг хандлага ажиглагдаж байна. Тухайлбал 2019 онд малын тооны нийт өсөлтийн 66.4 хувийг хонин сүргийн тооны өсөлт, 33.6 хувийг ямаан сүргийн тооны өсөлт хангаж байна.

Аймгийн хэмжээнд 9040.0 га-д үр тариа тариалсан ба үүний 8915.0 га-д буудай тариалжээ. Энэ онд 264.3 га-д төмс, 126.5 га-д хүнсний ногоо тариалсан байна.

Ургац хураалтын эцсийн мэдээгээр 10607.0 тн буудай, 2462.1 тн төмс, 1226.2 тн хүнсний ногоо, 1.1 мянган тн малын тэжээл хураан аваад байна.

Малчдын өөрсдийн бэлтгэсэн хадлан 74.8 мянган тн, гаднаас худалдаж авсан нь 6.3 мянган тн байна. Нийт бэлтгэсэн хадлан нь өмнөх оны мөн үеэс 4.1 мянган тонноор гар тэжээл 38.7 мянган тн-оор илүү байна.

Мал аж ахуйн салбарын өсөлт нь хүн амын хүнсний хэрэглээнд нийлүүлж байгаа дотоодын хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлж, үндэсний үйлдвэрлэлийг түүхий эдээр хангах боломжийг бүрдүүлэн, экспортын бүтээгдэхүүний тоо хэмжээ, үнийг өсгөн улмаар уг салбарын орлогын хэмжээг нэмэгдүүлэх таатай нөхцөл болж байна.

Мал аж ахуйн салбарын үйлдвэрлэлд гарч байгаа өсөлт нь малын тооноос хамаарч байгаа бөгөөд цаашид нэг малын ашиг шим, чанарын үзүүлэлтэд анхаарлаа хандуулж, энэ чиглэлээр тодорхой арга хэмжээ үе шаттайгаар авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. Ялангуяа мал аж ахуйн салбар ашиг шим өндөртэй мал үржүүлэх, малыг суурин болон бэлчээрийн хосолсон маллагаанд шилжүүлэх, малчдын хөдөлмөрийг хоршуулах, бэлчээрийг усжуулахад чиглэсэн арга хэмжээ ихээхэн чухал юм.

Бэлчээрийн доройтол нь малын тоо толгойг хязгаартай байлгахыг шаардаж байна. Ялангуяа бэлчээрт халтай ямаан сүргийн тоо толгойг хязгаарлах, бог малын хувьд өсгөж үржүүлж ирсэн уламжлалт харьцаа 75:25 хувь буюу 3 хонь, 1 ямаа гэсэн харьцаагаар өсгөж үржүүлэхэд татварын бодлогоор зохицуулах нь зүйтэй.

Цаашлаад мал маллагааны арга ажиллагааг залуу үед сургах арга хэмжээ шаардлагатай байна.

Хамгийн гол асуудал бол орон нутагт хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг хадгалах, боловсруулах, борлуулах чиглэлээр жижиг, дунд үйлдвэрүүдийг байгуулах, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг бэлтгэх төвлөрсөн газрууд, хадгалах, хөргөх агуулах, зоорийг бий болгох нь чухал байна.